

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР /2014 ОНЫ БАЙДЛААР/
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 5 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн С.Дэмбэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг /2014 оны байдлаар/ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4-д заасны дагуу 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн билээ.

Уг асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2015 оны 4 дүгээр сарын 28, 5 дугаар сарын 06-ны өдрүүдийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 бүлэг, 319 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн танилцуулгад хөтөлбөрийн хэрэгжилт 2014 оны байдлаар дунджаар 56.9 хувийн биелэлттэй байгаагаас бүрэн хэрэгжсэн 18, 90 хувийн хэрэгжилттэй 20, 80 хувийн хэрэгжилттэй 3, 70 хувийн хэрэгжилттэй 57, 60 хувийн хэрэгжилттэй 33, 50 хувийн хэрэгжилттэй 96, 40 хувийн хэрэгжилттэй 34, 30 хувийн хэрэгжилттэй 48, 10 хувийн хэрэгжилттэй 6, хэрэгжиж эхлээгүй 1 зорилт байна.

Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнээс 30 хүртэл хувийн биелэлттэй арга хэмжээ нь гол төлөв санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй, хууль эрх зүйн орчин бүрдээгүй байсан зэрэг шалтгаантай байна.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, А.Бакей, Н.Батцэрэг, Х.Тэмүүжин, Б.Гарамгайбаатар, Р.Гончигдорж, Г.Уянга нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлдсэн хугацаанд хэрэгжилт удаашралтай байгаа зорилт, арга хэмжээг төсөв, ач холбогдлоор нь эрэмбэлэн хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, хэрэгжиж эхэлсэн бүтээн байгуулалтын зорилт, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь биелүүлэхэд анхаарч хэрэгжилтийг түргэтгэх, Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөтөлбөрийг мөрдөж, төрийн бодлогын залгамж чанарыг хангаж ажиллахад анхаарах, Улсын Их Хуралд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа гүйцэтгэл, үр дүнг тооцох аргачлал, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох, хэрэгжилтийг хангахтай холбогдсон төлөвлөлт, санхүүжилт, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хөтөлбөрт тусгагдан хэрэгжилтийг нь дүгнэсэн зорилт, арга хэмжээг өөрчлөн хэрэгжүүлэхгүй байх зэрэг саналуудыг гаргав.

Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, М.Энхболд, Н.Энхболд нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах үетэй харьцуулахад төсөв эдийн засгийн нөхцөл байдал одоо өөр болсон, “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэхэд илүү анхаарал хандуулах шаардлагатай талаар

санал хэлсэн болно.

Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулах, түүний хэрэгжилтийг дүгнэх, хэлэлцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн /2014 оны байдлаар/ талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



А.БАКЕЙ